

ЗЭЭЛИЙН ДУГААР 5489-МН

МОНГОЛ УЛС,

ОЛОН УЛСЫН ХӨГЖЛИЙН АССОЦИАЦИ

хоорондын

САНХҮҮЖИЛТИЙН ХЭЛЭЛЦЭЭР

(Цахим эрүүл мэнд төсөл)

Огноо: 2015 оны сарын өдөр

Монгол Улсын Гадаад хэргийн яам АЛБАН ЁСНЫ ОРЧУУЛГА МӨН	
Гарын үсэг /Signature/ 	
20  оны  сарын  өдөр Улаанбаатар хот	
Ministry of Foreign Affairs of Mongolia OFFICIAL TRANSLATION	

ЗЭЭЛИЙН ДУГААР 5489-MN

САНХҮҮЖИЛТИЙН ХЭЛЭЛЦЭЭР

Энэхүү Хэлэлцээрийг МОНГОЛ УЛС (цаашид “Хүлээн авагч” гэх) болон ОЛОН УЛСЫН ХӨГЖЛИЙН АССОЦИАЦИ (цаашид “Ассоциаци” гэх)-ийн хооронд 2015 оны дугаар/дүгээр сарын.....—ны/ний өдөр байгуулав.

Хүлээн авагч болон Ассоциаци нь дараах зүйлсийг хэлэлцэн тохиролцов. Үүнд:

1 ДҮГЭЭР ЗҮЙЛ — ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ; НЭР ТОМЬЁО

- 1.01. Ерөнхий нөхцөл (энэхүү Хэлэлцээрийн Нэмэлтэд тодорхойлсноор) нь энэхүү Хэлэлцээрийн салшгүй хэсэг мөн.
- 1.02. Тухайн агуулгад өөрөөр заагаагүй тохиолдолд, энэхүү Хэлэлцээрд том үсгээр тэмдэглэсэн нэр томъёо нь Ерөнхий нөхцөл, эсхүл энэхүү Хэлэлцээрийн Нэмэлтэд тэдгээрийг тодорхойлсон утгыг илэрхийлнэ.

2 ДУГААР ЗҮЙЛ — САНХҮҮЖИЛТ

- 2.01. Ассоциаци нь энэхүү Хэлэлцээрт заасан, эсхүл дурдсан нөхцөлийн дагуу арван хоёр сая долоон зуун мянган Зээлжих Тусгай Эрх (3ТЭ 12,700,000) - тэй тэнцэх хэмжээний зээл (“Зээл” буюу “Санхүүжилт”)-ийг энэхүү Хэлэлцээрийн Хуваарь 1-д тодорхойлсон төслийг (“Төсөл”) санхүүжүүлэхэд туслалцаа үзүүлэх зорилгоор Хүлээн авагчид олгохыг зөвшөөрч байна.
- 2.02. Хүлээн авагч нь энэхүү Хэлэлцээрийн Хуваарь 2-ын IV дэх хэсэгт заасны дагуу санхүүжилтийн эх үүсвэрийг татан авч болно.
- 2.03. Санхүүжилтийн эх үүсвэрийн татан аваагүй үлдэгдэлд Хүлээн авагчийн зүгээс Хөрөнгө нөөцлөн баталгаажуулсны жилийн хураамжийн дээд хэмжээ нь жилд нэг хувийн хагас (1%-ийн 1/2) байна.
- 2.04. Татаж авсан зээлийн дүнд Хүлээн авагчийн зүгээс төлөх Үйлчилгээний хураамж нь жилд 1 хувийн дөрөвний гурав (1%-ийн 3/4) байна.
- 2.05. Татаж авсан зээлийн дүнд Хүлээн авагчийн зүгээс төлөх хүүгийн хураамж нь нь жилд нэг зууны хорин таван хувь (1.25%) байна.
- 2.06. Төлбөр хийгдэх өдрүүд нь жил бүрийн 3 дугаар сарын 1 болон 9 дүгээр сарын 1-ний өдөр байна.



- 2.07. Зээлийн үндсэн дүнгийн эргэн төлөлтийг энэхүү Хэлэлцээрийн Хуваарь 3-д заасан эргэн төлөлтийн хуваарийн дагуу хийнэ.
- 2.08. Төлбөрийн валют нь америк доллар байна.

3 ДУГААР ЗҮЙЛ — ТӨСӨЛ

- 3.01. Хүлээн авагч нь төслийн зорилтуудыг хангах үүрэг хүлээж байгаагаа үүгээр мэдэгдэж байна. Үүнтэй холбогдуулан Хүлээн авагч нь энэхүү төслийн үйл ажиллагааг Эрүүл мэнд, спортын яамаар дамжуулан, Ерөнхий нөхцөлийн 4 дүгээр зүйлд заасны дагуу хэрэгжүүлнэ.
- 3.02. Энэхүү Хэлэлцээрийн 3.01 дэх хэсэгт зааснаар хязгаарлагдахгүйгээр, мөн Хүлээн авагч тал болон Ассоциаци өөрөөр тохиоогүй бол, Хүлээн авагч нь төслийг энэхүү Хэлэлцээрийн Хуваарь 2-д заасны дагуу хэрэгжүүлнэ.

4 ДҮГЭЭР ЗҮЙЛ — ЦУЦЛАХ

- 4.01 Хүчин төгөлдөр болох эцсийн хугацаа нь энэхүү Хэлэлцээрт гарын үсэг зурсан өдрөөс хойш нэг зуун хорь (120) дахь хоног байна.
- 4.02 Ерөнхий нөхцөлийн 8.05 (б) дахь хэсгийн зорилгоор, Хүлээн авагч талын энэхүү Хэлэлцээрийн дагуу хүлээх үүрэг (төлбөрийн үүргээс бусад) нь энэхүү Хэлэлцээр хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш хорин (20) жилийн дараа дуусгавар болно.

5 ДУГААР ЗҮЙЛ — ТАЛУУДЫН ТӨЛӨӨЛӨЛ; ХАЯГ

- 5.01. Хүлээн авагчийн төлөөлөл нь түүний Сангийн Сайд байна.
- 5.02. Хүлээн авагчийн хаяг:

Сангийн яам
Засгийн газрын 2-р байр
Нэгдсэн Үндэстний гудамж - 5/1
Улаанбаатар 15015
МОНГОЛ УЛС
Факс: 976-11-327914

- 5.03. Ассоциацийн хаяг:
International Development Association
1818 H Street, N.W.
Washington, D.C. 20433
United States of America

Кабель: Телекс: Факс:

Монгол Улсын Гадаад хэргийн яам
АЛБАН ЁСНЫ ОРЧУУЛГА МӨН

Гарын үсэг /Signature/

2015. оны 12 сарын 28-д
Улаанбаатар хот

Ministry of Foreign Affairs of Mongolia
OFFICIAL TRANSLATION

INDEVAS
Washington, D.C.

248423(MCI)

1-202-477-6391

Энэхүү хэлэлцээрийн эхэнд заасан он, сар, өдрөөр Монгол улсын Улаанбаатар хотноо
ХАРИЛЦАН ТОХИРОЛЦЖ БАЙГУУЛАВ.

МОНГОЛ УЛСЫГ ТӨЛӨӨЛЖ:

_____ Эрх олгогдсон төлөөлөл

Нэр _____

Албан тушаал: _____

ОЛОН УЛСЫН ХӨГЖЛИЙН АССОЦИАЦИЙГ ТӨЛӨӨЛЖ:

_____ Эрх олгогдсон төлөөлөл

Нэр _____

Албан тушаал: _____



ХУВААРЬ 1

Төслийн танилцуулга

Төслийн зорилго нь сонгогдсон туршилт хийгдэх байршуулдад илүү чанартай эрүүл мэндийн үйлчилгээг үзүүлэхэд цахим эрүүл мэндийн шийдлүүд болон эрүүл мэндийн мэдээллийн ашиглалт болон нэгдмэл байдлыг сайжруулах явдал юм.

Төсөл нь дараах хэсгүүдээс бүрдэнэ:

Хэсэг 1: Цахим эрүүл мэндийн үндсэн үйл ажиллагаа

1.1 Энтэрпрайз архитектурийн бүтэц бий болгох

1. Үндэсний энтэрпрайз архитектурын бүтцийг нэвтрүүлэх, эрүүл мэндийн салбарыг нэвтрүүлэх, эрүүл мэндийн тодорхой нэг домэйнд тохирох энтэрпрайз архитектурыг хөгжүүлэх. Үүнд: эрүүл мэндийн байгууламж дахь одоогийн бизнесийн үйл явцын дүн шинжилгээ, мөн энтэрпрайзын мэдээллийн системд шаардлагатай элементүүдийн цаашдын хөгжил багтана.

1.2 Эрүүл мэндийн өгөгдөлийн стандарт

Хүлээн авагчийн эрүүл мэндийн салбар дахь олон янзын компьютерийн систем хоорондоо зохицон ажиллахад шаардагдах нийтлэг хэлийг бий болгохын тулд эрүүл мэндийн өгөгдөлийн иж бүрэн стандартыг тогтоох.

Хэсэг 2: Клиникийн өгөгдөл цуглувалт, ашиглалт, солилцоо

2.1 Цахим эрүүл мэнд портал ба дэлгэн харуулагч

Хэрэглэгчдэд зориулж эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэгч болон өгөгдлийн ашиглалт хооронд стандартчилгэсэн өгөгдөл солилцох суурийг хөгжүүлэх, Үүнд: а) компьютерийн архитектур; б) электрон эрүүл мэндийн мэдээллийн системийг цаашид бүрэн ажилладаг болгох веб-портал программ болон холбоосууд; в) портал дээр зохих түвшний хувийн нууц, нууцлалыг хадгалах аюулгүй байдлын тогтолцоо

2.2 Эрүүл мэндийн мэдээллийн солилцооны платформ

а) Зурvas/Мэдээ илгээлтийг хөнгөвлөх, өвчтөнийг үргэлжлүүлэн хянах ажил болон өвчтөнийг бусад эрүүл мэндийн үйлчилгээ рүү явуулах ажлыг сайжруулахын тулд; мөн б) бусад үйлчилгээтэй (ялангуяа, эрүүл мэндийн даатгалтай холбоотой болон эрүүл мэндийн үйлчилгээ ашиглалтын тайлан, өвчний тархалтын судалгаатай холбоотой) мэдээлэл солилцох боломжийг



бий болгохын тулд эрүүл мэндийн мэдээллийн солилцооны платформ (ЭММСП)-ыг хөгжүүлэх.

2.3 Зураг архивлах болон харилцааны системийг ажиллуулах болон дүн шинжилгээ хийх

Эрүүл мэндийн зургийг хадгалах нэгдсэн төв архив болон харилцааны орчинг хөгжүүлэх, дижитал зураг ашиглаж болохуйц сонгогдсон төхөөрөмжийг шинэчлэх болон дотоодын сүлжээг дижитал зураг харагдаг байхаар сайжруулах.

2.4 Мэдээллийн технологийн дэд бүтэц, засвар үйлчилгээ болон дэмжлэг, туршилт

(а) ЭММСП-д болон төслийн 2.1 ба 2.2-р хэсгийн дагуу хөгжүүлсэн клиникийн болон дүрсний өгөгдөл солилцооны механизмыг турших туршилтад шаардагдах серверүүдийг олж авч суурилуулах

(б) Төслийн 2.1 ба 2.2-р хэсгийн дагуу хөгжүүлсэн клиникийн болон дүрсний өгөгдөл солилцооны механизмыг турших туршилтыг явуулах

Хэсэг 3 Эрүүл Мэндийн Мэдээллийн Үндэсний Төв

3.1 ЭММУТ – ийн стандарт болон программ

Цахим эрүүл мэндтэй холбоотой үйл ажиллагааг удирдан хянах Эрүүл Мэндийн Мэдээллийн Үндэсний Төвийг байгуулах ба ЭММУТ нь дараах үйл ажиллагаа явуулна:

(а) Эрүүл мэндийн өгөгдөл мэдээллийн стандартыг тодорхойлох, дэлгэрүүлэн түгээх, мөрдүүлэх

(б) Зориулалтын цахим эрүүл мэндийн программыг зохиох болон бүтээхэд дэмжлэг үзүүлэх

3.2 Эрүүл мэндийн өгөгдөл мэдээллийн статистик

Эрүүл мэндийн өгөгдөл мэдээллийн агуулах системийг байгуулж, эхний үйл ажиллагааг явуулах. Үүнд: көмпьютерийн техник хангамжийг, өгөгдөл мэдээллийн баазыг удирдах программ хангамжийг, мөн эрүүл мэндийн өгөгдөл мэдээллийн агуулах системийг шинжлэх хэрэгслийг олж аван суурилуулах

Хэсэг 4: Байгууллагын үйл ажиллагааг бэхжүүлэх болон чадавхижуулах

Дараахь сургалтын болон чадавхижуулах үйл ажиллагааг явуулна:
Монгол Улсын Гадаад хэргийн яам
АЛБАН ЁСНЫ ОРЧУУЛГА МӨН

- (а) Эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэгчдийн компьютер ашиглах чадварыг сайжруулах зорилгоор хэрэглэгчдийг сургалтаар хангах;
- (б) ЭММҮТ-ийн ажилтнуудын мэдээллийн технологийн ур чадвар, мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор мэдээлийн технологийн техникийн сургалтаар хангах

Хэсэг 5: Төслийн удирдлага

Төслийг хэрэгжүүлэх, удирдах, хянах болон үнэлгээ хийхэд дэмжлэг үзүүлэх, тухайлбал, техникийн туслалцаа болон сургалтаар хангах.



ХУВААРЬ 2

Төслийн гүйцэтгэл

Хэсэг 1. Хэрэгжүүлэх ажлын уялдаа зохицуулалт

А. Институцийн болон хэрэгжүүлэлтийн зохицуулалтууд

1. Төслийн хэрэгжилтийг хангах зорилгоор, Хүлээн авагч тал ЭМСЯ-ны бүтцэд Төсөл хэрэгжүүлэх нэгжийг байгуулж, цаашид төсөл хэрэгжих хугацааны туршид ажиллуулна. Төсөл хэрэгжүүлэх нэгж нь энэхүү Хуваарь 2-ын З дахь хэсэгт заасны дагуу хангалттай тооны ажилтантай байна. Үүнд: төслийн удирдагч, худалдан авах ажиллагааны мэргэжилтэн, санхүү удирдлагын мэргэжилтэн, энтээрпрайз архитектурын мэргэжилтэн, клиникийн эмч, өөрчлөлтийн удирдлагын мэргэжилтэн багтах бөгөөд үүгээр хязгаарлагдахгүй болно. Төсөл хэрэгжүүлэх нэгж нь төслийн хэрэгжилтийг, тухайлбал, төслийн ерөнхий удирдлага, санхүүгийн удирдлага, хяналт болон үнэлгээ болон төслийн тайланг хариуцна.

2. Төслийг хяналт болон стратеги бодлогын зөвлөгөө ба удирдамжаар хангах зорилгоор, Хүлээн авагч нь Төслийн удирдах хороог байгуулж, цаашид төсөл хэрэгжих хугацааны туршид ажиллуулна. Төслийн удирдах хороог Эрүүл мэнд, спортын сайд ахлах бөгөөд хорооны бүрэлдэхүүн нь Ассоциацийн зүгээс хүлээн зөвшөөрөхүйц эдийн засгийн хөгжил болон санхүүгийн харилцаа хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын төлөөлөгчдөөс бүрдэнэ. Төслийн удирдах хороо нь уг төсөл болон Хүлээн авагчийн бусад холбогдох үйл ажиллагаанууд ба төслүүдийн хоорондын үр ашигт хамтын ажиллагааг хангах үүрэгтэй.


3. Хүлээн авагч нь:

(а) Гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш 6 сарын дотор Ассоциацийн зүгээс хүлээн зөвшөөрөхүйц ҮЭММТ-д ажиллах үндсэн техникийн ажилтнуудын ажлын байрыг бэлтгэнэ.

(б) 2017 оны 1 дүгээр сарын 1-ний өдрийн дотор өмнөх дэд хэсэгт дурдсан техникийн ажилтнуудын ажлын байрыг бий болгож, уг ажлын байруудыг Ассоциацийн зүгээс хүлээн зөвшөөрөх түвшний мэдлэг чадвар туршлагатай ажилтнуудаар төсөл хэрэгжих хугацаанд хангана.

Б. Төсөл хэрэгжүүлэх гарын авлага

1. Хүлээн авагч нь Төсөл хэрэгжүүлэх нэгжийн ажил үүргийн хуваарилалт, үйл ажиллагааны систем болон журам, тухайлбал, Төсөл хэрэгжүүлэх нэгжийн зохион байгуулалтын бүтэц, оффисын үйл ажиллагаа болон санхүү ба нягтлан бодох бүртгэлийн журам (үүнд, хөрөнгийн урсгал, зарцуулалтын зохицуулалт), худалдан авах ажиллагааны журмыг багтаасан Төсөл хэрэгжүүлэх заавар бэлтгэж, батлана.



2. Хүлээн авагч нь Төсөл хэрэгжүүлэх зааварт заасны дагуу төслийг хэрэгжүүлэх бөгөөд Ассоциациас урьдчилж бичгээр зөвшөөрөл авалгүйгээр уг зааварт нэмэлт, өөрчлөлт оруулах, эсхүл засварлаж болохгүй. Төсөл хэрэгжүүлэх заавар болон энэхүү Хэлэлцээрийн зүйл хоорондоо нийцэхгүй тохиолдолд энэхүү Хэлэлцээрийн зүйлүүдийг мөрдөнө.

C. Авлигатай тэмцэх

Хүлээн авагч нь Төслийг Авлигын эсрэг дагаж мөрдөх журмын заалтуудын дагуу хэрэгжүүлэх явдлыг хангана.


Хэсэг II. Төслийн хяналт, тайлагнал, үнэлгээ

A. Төслийн тайлан

1. Хүлээн авагч нь Ерөнхий нөхцөлийн 4.08 дахь хэсэгт болон Төсөл хэрэгжүүлэх зааварт заасны дагуу Ассоциацийн хүлээн зөвшөөрөхүйц үзүүлэлтээр Төслийн тайланг бэлтгэж, Төслийн үйл явцад хяналт тавьж, үнэлгээ хийнэ. Төслийн тайлан тус бүр хуанлийн нэг (1) хагас жилийг хамарсан байх бөгөөд тайланг тухайн тайлангийн хамрах хугацаа дууссанаас хойш нэг (1) сараас хэтрэхгүй хугацааны дотор Ассоциацид хүргүүлнэ.

B. Санхүүгийн удирдлага, санхүүгийн тайлан ба аудит

1. Хүлээн авагч нь Ерөнхий нөхцөлийн 4.09 дэх хэсгийн дагуу санхүүгийн удирдлагын системийг нэвтрүүлж хэрэглэх, эсхүл нэвтрүүлж хэрэглэх нөхцөлийг бүрдүүлнэ.
2. Энэхүү Хэсгийн А Хэсэгт дурдсан заалтуудаар хязгаарлахгүйгээр, Хүлээн авагч нь хуанлийн улирлыг хамарсан, аудитаар баталгаажуулаагүй санхүүгийн дунд шатны тайланг Ассоциацийн шаардлагад нийцсэн хэлбэр, агуулгатайгаар бэлдэж тайлант хугацаа дууссанаас хойш 45 хоногийн дотор Ассоциацид хүргүүлнэ.
3. Хүлээн авагч нь Санхүүгийн тайланг Ерөнхий нөхцөлийн 4.09(б) дэх хэсгийн дагуу аудитаар баталгаажуулсан байна. Санхүүгийн тайлангийн аудит бүр нь Хүлээн авагчийн санхүүгийн нэг (1) жилийг хамарсан байна. Аудитаар баталгаажуулсан, тухайн хамрагдах хугацааны Санхүүгийн тайланг тайлангийн хамрах тухайн хугацаа дуусгавар болсноос хойш зургаан (6) сараас хэтрэхгүй хугацаанд багтаан гаргаж Ассоциацид хүргүүлнэ.



Хэсэг III. Худалдан авах ажиллагаа

A. Ерөнхий

1. **Бараа болон зөвлөхийн бус үйлчилгээ.** Тус Хэлэлцээрийн хүрээнд олгогдох эх үүсвэрээр санхүүжих энэхүү төсөлд шаардлагатай бүх бараа болон зөвлөхийн бус үйлчилгээний худалдан авалтыг “Худалдан авах ажиллагааны журам”-ын I хэсэгт тусгасан, эсхүл дурдсан шаардлагын болон энэхүү хэсэгт заасны дагуу явуулна.
2. **Зөвлөхийн үйлчилгээ.** Тус Хэлэлцээрийн хүрээнд олгогдох эх үүсвэрээр санхүүжих энэхүү төсөлд шаардлагатай бүх зөвлөхийн үйлчилгээний худалдан авалтыг “Зөвлөх сонгон шалгаруулах журам”-ын I болон IV хэсэгт тусгасан, эсхүл дурдсан шаардлагын болон энэхүү хэсэгт заасны дагуу явуулна.
3. **Нэр томъёо.** Энэхүү Хэсэгт худалдан авах арга, эсхүл тодорхой гэрээг Ассоциаци хянан үзэх аргыг тодорхойлон том үсгээр бичсэн доорх нэр томъёонууд нь Худалдан авах ажиллагааны журмын II, III хэсэг болон Зөвлөхийн үйлчилгээний журмын II, III, IV, V хэсэгт тодорхойлсон холбогдох аргуудад хамаарна.

B. Бараа болон зөвлөхийн бус үйлчилгээ худалдан авах тодорхой аргууд

1. **Олон улсын нээлттэй тендер шалгаруулалт.** Дор дурдсан 2 дахь хэсэгт өөрөөр заагаагүй бол, бараа болон зөвлөхийн бус үйлчилгээний худалдан авалтыг Олон улсын нээлттэй тендер шалгаруулалт явуулж, шалгарсан гэрээний дагуу хийнэ.
2. **Бараа, зөвлөхийн бус үйлчилгээ худалдан авах бусад аргууд.** Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан гэрээнүүдийн хүрээнд бараа, зөвлөхийн бус үйлчилгээний худалдан авалтыг хийхэд Олон улсын нээлттэй тендер шалгаруулалтаас бусад худалдан авах ажиллагааны дараах аргуудыг хэрэглэж болно: (а) Гэрээ шууд байгуулах арга; (б) Харьцуулалтын арга; (в) дор дурдсан нэмэлт заалтууд бүхий Дотоодын нээлттэй тендер шалгаруулалтын арга. Үүнд:

Дотоодын нээлттэй тендер шалгаруулах нэмэлт журам

a) Худалдан авах ажиллагааны холбогдох журам

Тендерийн шалгаруулалтыг 2005 оны 12-р сарын 1-нд батлагдсан (2011 оны 6-р сарын 16 хүртэл оруулсан нэмэлт өөрчлөлтийг оролцуулан) Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн



2-р Бүлэг болон Нээлттэй тендер шалгаруулалтын журмын дагуу дараах нөхцөлтэйгээр явуулна. Үүнд:

б) Тендер шалгаруулалтанд оролцох, давуу эрх олгох

(i) Зөвхөн хууль эрх зүйн болон санхүүгийн хувьд бие даасан, худалдаатай холбоотой хууль тогтоомжийн дагуу үйл ажиллагаагаа явуулдаг, Хүлээн авагчийн харьяа байгууллага бус гэдгээ нотолсон Монгол улсын Төрийн өмчийн байгууллагууд Тендерт оролцох эрхтэй байна.

(ii) Дэлхийн Банкнаас санхүүжүүлж буй гэрээний төлөө өрсөлдөх, эсхүл тийм гэрээг гүйцэтгэх явцад авлигатай холбогдох болон хууран мэхлэх, хуйвалдах, дарамтлах буюу саад тогтор учруулах үйлдэлд холбогдсоныг Дэлхийн Банкнаас тодорхойлсны үндсэн дээр Тендерт оролцогчийг Дэлхийн Банкнаас тендерт оролцох эрхгүй гэдгийг зарлаж тунхагласан тохиолдолд Дэлхийн Банкнаас тогтоосон хугацааны туршид Дэлхийн Банкнаас санхүүжүүлж буй гэрээ байгуулах эрхийг уг оролцогчид олгохгүй байна.

(iii) Төслийг бэлтгэх, эсхүл хэрэгжүүлэхэд зөвлөхийн үйлчилгээ үзүүлж буй Хүлээн авагчийн ажиллуулж буй компани болон түүний харьяа аливаа байгууллага нь төсөл бэлтгэх, эсхүл хэрэгжүүлэхтэй холбогдсон түүний зөвлөх үйлчилгээний үр дүнд худалдан авах, эсхүл зөвлөх үйлчилгээнд шууд хамаарах бараа бүтээгдэхүүн нийлүүлэх, ажил гүйцэтгэх бол уг компанийг шаардлагад нийцээгүй гэж үзэж хасна. Энэхүү заалт нь түлхүүр гардуулах гэрээ, эсхүл зураг төсөл болон барилга угсралтын ажлын гэрээгээр хүлээсэн Гүйцэтгэгчийн үүргийг хамтран гүйцэтгэж байгаа төрөл бүрийн компаниудад үйлчлэхгүй болно.

(iv) Тендерт оролцох сонирхолтой этгээдүүд тендерийн баримт бичиг авах хүсэлтээ бичгээр ирүүлсэн тохиолдолд уг баримт бичгийн хүсэлтийг биечлэн буюу шуудангаар авахыг зөвшөөрнө. Тендерийн баримт бичгийг түүний үнийг төлж авах хүсэлтэй аливаа хүнд худалдаж болох бөгөөд худалдах үнэ нь тухайн баримт бичгийг хэвлэх болон хүргэх зардаас хэтрэхгүй байна.

(v) Зөвшөөрөгдсөн улс орнуудаас тендерт оролцох сонирхолтой гадаадын этгээдүүдэд дотоодын оролцогчидтой хамтрахгүйгээр, эсхүл хамтарсан аж ахуйн нэгж байгуулахгүйгээр тендерт оролцохыг зөвшөөрнө. Гадаадын оролцогчид нь дотоодын оролцогчидтой адил нөхцөлтэйгээр тендерт оролцох эрхээр хангагдана. Тендер шалгаруулалтын болон тендерийн үнэлгээний явцад Монголын оролцогчид болон Монгол улсын гарал үүсэлтэй бараанд Гадаадын оролцогчдоос давуу эрх олгохыг хориглоно.

(vi) Тендерт оролцох аливаа оролцогчдод урьдчилан бүртгүүлэх шаардлага тавихыг хориглоно.

(vii) Томоохон цар хүрээтэй, эсхүл цогц ажил болон Дэлхийн Банкнаас бичгээр урьдчилан зөвшилцсөнөөс бусад тохиолдолд гэрээлэгчээс урьдчилсан шаардлага тавихгүй.

в) Тендер шалгаруулалтыг зарлан мэдээлэх, тендерт бэлтгэх хугацаа

Тендерийн урилгыг үндэсний хэмжээний, өргөн тархалттай нэгээс доошгүй сонин хэвлэлээр зарлан мэдээлэх ба тендерийн материал боловсуулах, бэлтгэж ирүүлэхэд хангалттай буюу 30 өдрөөс доошгүй хугацаа олгоно. Тендерийн баримт бичгийг хангалттай буюу 30 өдрөөс доошгүй хугацаа олгоно. Тендерийн баримт бичгийг цахим хэлбэрээр түгээж болох бөгөөд энэ тохиолдолд тухайн цахим систем нь Дэлхийн Банкны шаардлагад нийцсэн байвал зохино.

г) Тендерийн стандарт баримт бичиг

Дэлхийн Банкны шаардлагад нийцсэн тендерийн стандарт баримт бичгийг хэрэглэнэ. Тендерийн баримт бичигт тендерийг хэрхэн ирүүлэх, үнийг хэрхэн санал болгох, тендерээ ирүүлэх газар, хугацаа болон тендер нээх цагийг тодорхой заасан байна. Тендерт оролцогчид тендерээ биеэр болон шуудангаар, эсхүл шуудан зөөгчөөр хүргүүлэхийг зөвшөөрнө.

д) Тендерт оролцогчдын чадварын үнэлгээ

Тендерийн баримт бичигт чадварын шалгуур үзүүлэлтийг тодорхой заасан байх бөгөөд зөвхөн эдгээр шалгуур үзүүлэлтээр тухайн оролцогчийн энэ тендерт оролцох чадавхитай эсэхийг тодорхойлно. Тендерт оролцогчийн чадварын үнэлгээг тендерийн техникийн болон үнийн саналын үнэлгээнээс тусдаа хийнэ. Чадварын үнэлгээг шалгаруулалтын дараагийн шатанд хийх тохиолдолд Хүлээн авагч нь тендерт оролцогчийн чадварын үнэлгээг зөвхөн тендерийн урьдчилсан болон дэлгэрэнгүй үнэлгээ хийсний дараа хийх бөгөөд ингэхдээ шаардлагад нийцсэн хамгийн бага харьцуулах үnэтэй гэж үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогчийн чадварыг эхний ээлжинд үнэлнэ. Оролцогчийн чадварын үнэлгээнд гэрээг хэрэгжүүлж гүйцэтгэхэд шаардлагатай оролцогчийн чадавх, гэрээг гүйцэтгэх нөөц боломж, ялангуяа ижил төстэй гэрээн дээр ажилласан туршлага, гүйцэтгэсэн байдал, түүний хүн хүчний хангамж, тоног төхөөрөмж, барилгын, эсхүл чадварын үнэлгээг шалгаруулалтын дараагийн шатанд хийхдээ Хүлээн авагч нь оролцогчоос зөвхөн түүний чадварт хамаарах, өмнө орхигдуулсан бодит мэдээлэл, эсхүл нотлох түүхэн баримт мэдээг бичгээр хүсэх бөгөөд хүсэлтэнд хариулах боломж олгох үүднээс түүнд боломжийн хугацаа (7 хоногоос доошгүй) олгоно.

е) Үнэлгээний шалгуур үзүүлэлтүүд

Тендерийн үнэлгээнд ашиглах шалгуур үзүүлэлтүүдийг тендерийн баримт бичигт тодорхой заасан байх бөгөөд үнээс бусад шалгуур үзүүлэлтүүдийг тоон

Монгол Улсын Гадаад хэргийн яам
АЛБАН ЁСНЫ ОРЧУУЛГА МӨН

Гарын үсэг /Signature/

2015. оны 08 сарын 28-д
Улаанбаатар хот

илэрхийлэлтэй болгох үүднээс мөнгөн хэлбэрт шилжүүлнэ. Тендерийн үнэлгээнд хэмжлийн оноог хэрэглэхийг хориглоно. Тендерийн үнэлгээ хийхдээ тендерийн баримт бичигт тусгасан шалгуур үзүүлэлтүүдийг чанд баримтлах бөгөөд шаардлагад нийцсэн, хамгийн бага харьцуулах үнийн санал ирүүлсэн оролцогчид гэрээ байгуулах эрх олгоно.

ё) Тендерийн нээлт болон тендерийн үнэлгээ

(i) Тендерийг тендерийн баримт бичигт заасан, тендер ирүүлэх товлосон хугацаа дуусмагц олон нийтийн өмнө нээнэ. Тендерийн нээлтэд тендерт оролцогчийн төлөөлөгч, мөн тендерийн нээлтэнд оролцохыг хүссэн холбогдох орон нутгийн төслийн үр ашиг хүртэгсэд оролцохыг зөвшөөрнө. Тендерт оролцогчийн нэр, тендер тус бүрийн үнийн дүнг үнийн хөнгөлөлтийн хамт чангаар уншиж, Тендерийн нээлтийн тэмдэглэлд бүртгэн тэмдэглэнэ. Тендер ирүүлэх товлосон хугацаанаас хоцорч ирүүлсэн тендерээс татгалзах бөгөөд нээлгүйгээр тухайн тендерт оролцогчид буцаана. Тендер нээх ажиллагаа дуусмагц Тендерийн нээлтийн тэмдэглэлийн хуулбарыг худалдан авах ажиллагаа явуулж буй байгууллагын гадна талд олон нийтэд ил тод харагдах газар байршуулж гэрээ байгуулах эрх олгосон тухай мэдэгдэл ирэх хүртэл анх байршуулсан газраа байлгана. Тендерийн нээлтийн тэмдэглэлийн хуулбарыг тендерээ ирүүлсэн бүх оролцогчдод яаралтай хүргүүлнэ. Дэлхийн Банкнаас урьдчилан хянах бүх гэрээтэй холбогдуулан Хүлээн авагч нь Тендерийн нээлтийн тэмдэглэлийн хуулбарыг Дэлхийн Банкинд хүргүүлнэ.

(ii) Дэлхийн Банктай урьдчилан бичгээр зөвшилцөөгүй тохиолдолд бүх тендерээс татгалзах, эсхүл шинэ тендерийн урилга явуулахыг хориглоно.

(iii) Дэлхийн Банктай урьдчилан бичгээр зөвшилцөөгүй тохиолдолд захиалагчийн зардлын тооцоолол болон төсвийн дээд хязгаартай харьцуулсны үндсэн дээр тендерээс татгалзахыг хориглоно.

(iv) Тендерийн баримт бичигт тусгасан нөхцөл, хугацаа, тодорхойлолтоос зөрсөн, эсхүл тэдгээрт огт нийцэхгүй байгаа тендерээс шаардлагад нийцээгүй гэсэн үндэслэлээр татгалзана. Тендер нээсний дараа Тендерт оролцогч огт нийцэхгүй байгаа буюу зөрчилтэй зүйлийг арилгахыг хориглоно. Ноцтой бус, бага зэргийн алдаа буюу үл ялих зөрүүтэй гэсэн үндэслэлээр тендерт оролцогчдыг Тендерийн дэлгэрэнгүй үнэлгээнээс хасахыг хориглоно.

(v) Тендерт оролцогчдоос зөвхөн онцгой тохиолдолд л тендерийнхээ хүчинтэй байх хугацааг сунгах хүсэлт гаргахыг зөвшөөрөх бөгөөд ийм бүх тохиолдолд Хүлээн авагч нь тендерийн хүчинтэй байх хугацаа дусахаас өмнө бүх оролцогчдод уг хүсэлтийг бичгээр хүргүүлсэн байна. Ийм тохиолдолд тендерт оролцогчид тендерийнхээ үнэ буюу аливаа бусад нөхцөлийг өөрчлөх, эсхүл тендерт оролцогчдоос өөрчлөх тухай хүсэлт гаргахыг хориглоно. Тендерт оролцогчид тендерийн баталгаагаа алдахгүйгээр өөрсдийн тендерийн хүчинтэй байх хугацааг сунгахаас татгалзах эрх эдлэх бөгөөд тендерийнхээ хүчинтэй байх хугацааг

Монгол Улсын Гадавд хэргийн яам
АЛБАН ЁСНЫ ОРЧУУЛГА МӨН

Гарын үсэг /Signature/
2015 оны 06 сарын 00
Улаанбаатар хот

сунгахыг зөвшөөрсөн оролцогчид тендерийн баталгааныхаа хугацааг мөн сунгасан байхыг шаардана.

(vi) Гэрээ 18 сараас урт хугацаанд үргэлжлэх тохиолдолд тендерийн баримт бичиг болон тендерийн үр дүнд байгуулах гэрээнд Дэлхийн Банкны шаардлагад нийцсэн томъёонд үндэслэн үнийн тодотголыг тусгасан байх бөгөөд уг томъёог тендерийн баримт бичигт тусган, тендерт оролцогчдод мэдэгдсэн байна.

(vii) Тендерийн үнэлгээний явцад Үнэлгээний хорооноос хийсэн арифметикийн залруулгыг хүлээн зөвшөөрөхөөс татгалзсан оролцогчийн тендерээс татгалзана.

(viii) Гэрээ байгуулах эрхийн нөхцөл болгож тендерийн баримт бичигт тусгаагүй үүрэг хүлээхийг, эсхүл анх ирүүлсэн тендер мөн гэж тендертээ өөрчлөлт оруулахыг тендерт оролцогчоос шаардахыг хориглоно.

(ix) Тендер дууссаны дараа хамгийн бага харьцуулах үнэтэй гэж үнэлгэдсэн тендер ирүүлсэн оролцогч болон бусад аливаа оролцогчтой хэлэлцээ хийхийг хориглоно. Гэрээ байгуулах эрхийн нөхцөл болгож тендерээ ирүүлсний дараа тендерийн үнийг өөрчлөх, эсхүл түүнд материалын чанартай аливаа өөрчлөлт оруулахыг тендерт оролцогчоос шаардахыг хориглоно.

ж) Ханган нийлүүлэгчид, Гэрээлэгч болон Туслан гэрээлэгчид

(i) Дэлхийн Банкнаас санхүүжүүлж буй гэрээний төлөө өрсөлдөх, эсхүл тийм гэрээг гүйцэтгэх явцад тухайн компани авлигатай холбоотой болон хууран мэхлэх, хуйвалдах, дарамтлах буюу саад тогтор учруулах үйлдэл өөрөө шууд буюу зуучлагчаар дамжуулан холбогдосныг Дэлхийн Банкнаас хэзээ нэгэн цагт тодорхойлсон тохиолдолд уг компани тодорхойгүй хугацаагаар буюу тогтоосон хугацааны туршид Дэлхийн Банкнаас санхүүжүүлэх гэрээ байгуулах эрхгүй болсон тухай Дэлхийн Банкнаас тунхаглан зарлана.

(ii) Дэлхийн Банкнаас санхүүжүүлж буй үндэсний өрсөлдөөнт тендер шалгаруулалтын журмын дагуу Дэлхийн Банкнаас шаардлагатай гэж үзвэл ханган нийлүүлэгч, гүйцэтгэгч болон туслан гүйцэтгэгчид тэдгээрийн данс, бүртгэлийг Дэлхийн Банкнаас шалгах, мөн Дэлхийн Банкнаас томилсон хараат бус аудитороор эдгээр данс, бүртгэлд аудит хийлгэхийг зөвшөөрсөн заалтыг тендерийн баримт бичиг болон гэрээнүүдэд тусгасан байна. Ханган нийлүүлэгч, гүйцэтгэгч болон дэд гүйцэтгэгчид нь ийм заалтыг санаатайгаар зөрчих болон ноцтой алдаа гаргах замаар зөрчсөн тохиолдолд үүнийг саад тогтор бий болгох үйлдэл гэж үзэх бөгөөд Журмын дагуу арга хэмжээ авна.

з) Гэрээ байгуулах эрх олгосон тухай нийтлэх

Хүлээн авагч нь Гэрээ байгуулах эрх олгох талаар дараах мэдээллийг Дэлхийн Банкнаас хүлээн зөвшөөрсөн, нийтэд хүртээмжтэй, ажиллагаатай вэб-хуудсанд, эсхүл хэвлэл мэдээллийн өөр хэрэгсэлд нийтлэнэ. Үүнд: (а) тендерээ ирүүлсэн

Монгол Улсын Гадаад хэргийн яам
АЛБАН ЁСНЫ ОРЧУУЛГА МӨН

Гарын үсэг /Signature/

20.05.2016 16.05.2016
оны 22. одөр
Улаанбаатар хот

Ministry of Foreign Affairs of Mongolia
OFFICIAL TRANSLATION

оролцогч тус бүрийн нэр; (б) тендерийн нээлтэнд уншигдсан тендерийн үнэ; (в) үнэлгээ хийгдсэн тендер тус бүрийн үнэлгээ хийгдсэн үнэ, тендерт оролцогчийн нэр; (г) татгалзсан тендер, түүнийг ирүүлсэн оролцогчдын нэр болон татгалзан шалтгаан; мөн (д) тендэрт шалгарсан оролцогчийн нэр, санал болгосон үнэ болон гэрээгээр гүйцэтгэх ажлын үргэлжлэх хугацаа, цар хүрээний хураангуй. Нийтэлсэн энэхүү мэдээллийг улирал тутам шинэчилнэ.

и) Тендэрт оролцогчдоос ирүүлсэн санал гомдол, тэдгээрийг хянан шийдвэрлэх

Монгол улсын Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7-р Бүлэгт тусгасан маргаан шийдвэрлэх тухай заалтууд нь Үндэсний өрсөлдөөнт тендер шалгаруулалтын хүрээнд байгуулсан, Дэлхийн Банкнаас санхүүжүүлсэн гэрээнүүдэд үйлчилнэ.

B. Зөвлөх сонгон шалгаруулах тодорхой аргууд

1. **Чанар ба үнийн хосломол үнэлгээний арга.** Доорх 2 дугаар хэсэгт өөрөөр заагаагүй бол зөвлөхийн үйлчилгээг Чанар ба үнийн хосломол үнэлгээний аргаар сонгон шалгаруулж гэрээ байгуулна.

2. **Зөвлөх сонгон шалгаруулах бусад аргууд:** Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан гэрээний худалдан авах ажиллагааны зөвлөхийн үйлчилгээнд Чанар ба үнийн хосломол үнэлгээний аргаас бусад дараах аргыг ашиглаж болно. Үүнд: (а) Чанарын үнэлгээний арга; (б) Хамгийн бага үнийн арга; (в) Чадварын үнэлгээний арга; (г) Нэг эх үүсвэрээс зөвлөх компанийг сонгон шалгаруулах арга; (д) Зөвлөх сонгон шалгаруулах журмын 5.2 болон 5.3-д заасан Хувь хүн зөвлөхөөр шалгаруулах арга; (е) Нэг эх үүсвэрээс хувь хүн зөвлөхөөр сонгон шалгаруулах арга.

G. Худалдан авах ажиллагааны шийдвэрийг Ассоциациас хянан үзэх

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд Ассоциациар урьдчилан хянах гэрээг тусгана. Ассоциаци бусад бүх гэрээнд дараагийн хяналт хийнэ.

Хэсэг IV. Санхүүжилтийн эх үүсвэрийг татан авах

A. Ерөнхий

1. Хүлээн авагч нь доорхи 2 дахь хэсгийн хүснэгтэнд заасан Зөвшөөрөгдөх зардлыг санхүүжүүлэх зорилгоор Ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйл, энэ бүлэг болон Ассоциациас Хүлээн авагчид мэдэгдсэний үндсэн дээр тогтоох бусад нэмэлт заавар (түүний дотор Ассоциациас тухай бүр нэмэлт өөрчлөлт оруулж, тэдгээр зааврын дагуу энэхүү гэрээнд хэрэглэх, 2006 оны 5 дугаар сард батлагдсан “Дэлхийн Банкны төслийн санхүүжилтийг зарцуулах удирдамж”)-ын дагуу санхүүжилтийн эх үүсвэрийг татан авч болно.



- Дараахь хүснэгтэд санхүүжилтийн эх үүсвэрээр санхүүжүүлж болох Зөвшөөрөгдөх зардлуудын ангилал (“Ангилал”), Ангилал тус бүрт хуваарилагдсан зээлийн хэмжээ, Ангилал тус бүрт Зөвшөөрөгдөх зардлыг санхүүжүүлэх зардлын хувь хэмжээг тодорхойлов:

Ангилал	Иарилагдсан зээлийн хэмжээ (Зээлжих тусгай эрхээр илэрхийлэгдсэн)	Үүжигдэх зардлуудын хувь (татварыг оролцуулан)
Эслийн 5-р хэсэгтэй холбогдох бараа,, зөвлөхийн бус үйлчилгээ, нэмэгдүүлсэн үйл ажиллагааны зардал, болон зөвлөхийн үйлчилгээ	750,000	
Пийн 1,2,3,4 дэх хэсэгтэй холбогдох бараа бүтээгдэхүүн, зөвлөхийн бус үйлчилгээ болон зөвлөхийн үйлчилгээ	11,950,000	
ДҮН	12,700,000	


Б. Санхүүжилт татан авах нөхцөл, хугацаа

1. Энэхүү Хэсгийн А Хэсгийн заалтуудыг үл харгалzan дараахь тохиолдолд төлбөр хийх зорилгоор хөрөнгийн татан авалт хийхийг хориглоно. Үүнд:

(а) Хэлэлцээр байгуулсан өдрөөс өмнө хийсэн;

(б) Ассоциацийн зүгээс хүлээн зөвшөөрөгдөх хэлбэрээр, мөн энэхүү Хэлэлцээрийн Хуваарь 2-ийн 1-р хэсгийн А хэсэгт заасны дагуу Төсөл хэрэгжүүлэх нэгж байгуулагдаж, Хүлээн авагч нь Ассоциацийн зүгээс хүлээн зөвшөөрөхүйц Төсөл хэрэгжүүлэх зааврыг ашиглах хүртэл.

2. Төсөл дуусгавар болон хугацаа нь 2020 оны 9 дүгээр сарын 30-ны өдөр байна.



ХУВААРЬ 3

Эргэн Төлөх Хуваарь

Эргэн Төлөх Өдөр	Зээлийн Эргэн Төлөгдөх Үндсэн Дүн
Тус бүр 3 дугаар сарын 1 ба 9 дүгээр сарын 1:	
2019 оны 9 дүгээр сарын 1 нээс эхлэн	1.65%
2029 оны 3 дугаар сарын 1	
2029 оны 9 дүгээр сарын 1 нээс эхлэн	3.35%
2039 оны 3 дугаар сарын 1	

*Ерөнхий нөхцлийн 3.03 (б) Хэсэгт Ассоциаци өөрөөр заагаагүй бол бусад тохиолдолд хувь нь зээлийн эргэн төлөгдөх үндсэн өрийн хувийг илэрхийлнэ.

Монгол Улсын Гадаад хэргийн яам
АЛБАН ЁСНЫ ОРЧУУЛГА МӨН

Гарын үсэг /Signature/

20¹⁵ оны 06 сарын 20 өдөр
Улаанбаатар хот

НЭМЭЛТ

Хэсэг I. Нэр томъёо

1. “Авиалын эсрэг журам” гэж 2006 оны 10-р сарын 15-нд баталсан, 2011 оны 1-р сард хянан шинэчилсэн “Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк (ОУСБХБ)-ны зээл болон Олон улсын хөгжлийн Ассоциаци (ОУХА)-ийн хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламжийн санхүүжилттэй төслүүдэд залилан мэхлэлт, авилгаас урьдчилан сэргийлж тэмцэх журам”-ыг хэлнэ.
2. “Ангилал” гэж энэхүү Гэрээний Хавсралт 2-ын 4 дэх Хэсгийн хүснэгтэд тусгасан ангиллыг хэлнэ.
3. “Зөвлөхийн үйлчилгээний журам” гэж 2011 оны 1-р сард баталсан “Дэлхийн Банкны зээлдэгчид ОУСБХБ-ны Зээл болон ОУХА-ийн хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламжийн хүрээнд зөвлөхүүдийг сонгон ажиллуулах журам”-ыг хэлнэ.
4. “Ерөнхий нөхцөл” гэж 2010 оны 7 дугаар сарын 31-ний өдөр баталсан, энэхүү Нэмэлтийн 2 дахь Хэсэгт заасан өөрчлөлтийг тусгасан, “Олон улсын хөгжлийн Ассоциацийн хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламжийн Ерөнхий нөхцөл”-ийг хэлнэ.
5. “ЭММСП” гэж энэхүү төслийн 2.2 дугаар хэсгийн хүрээнд хийгдэх эрүүл мэндийн мэдээллийн солилцооны платформыг хэлнэ.
6. “Нэмэгдүүлсэн үйл ажиллагааны зардал” гэдэг нь Ассоциаци урьдчилсан бичгээр зөвшөөрсөн тухайн жилийн төсөвт үндэслэн Төсөл хэрэгжүүлэхэд шууд холбогдон гарсан (төслөөс гадуурх зардал орохгүй) бодит зардлыг хэлнэ. Үүнд: хэрэглээний бараа материал, оффисын түрээс, харилцаа холбооны үйлчилгээ (шуудан, утас болон интернэтийн зардал), хэвлэн нийтлэх болон орчуулгын үйлчилгээ, оффисын талбайн түрээс болон ашиглалтын зардал, оффисын тоног төхөөрөмжийн үйл ажиллагааны зардал орох бөгөөд Хүлээн авагчийн төрийн үйлчилгээ үзүүлж буй гишүүдийн цалин, шимтгэл болон шагнал урамшуулал орохгүй.
7. “Сангийн Яам” гэдэг нь Хүлээн авагчийн Сангийн Яам болон түүний үйл ажиллагааг залгамжлагчийг хэлнэ.
8. “Эрүүл мэнд, спортын яам” гэдэг нь Хүлээн авагчийн Эрүүл мэнд, спортын яам болон түүний үйл ажиллагааг залгамжлагчийг хэлнэ.
9. “ҮЭММТ” гэж энэхүү төслийн 3 дахь хэсгийн дагуу байгуулагдаж, цаашид үйл ажиллагаагаа явуулах Үндэсний Эрүүл мэндийн мэдээллийн төвийг хэлнэ.
10. “Худалдан авах ажиллагааны журам” гэж 2011 оны 1-р сард баталсан “ОУСБХБ-ны зээл болон ОУХА-ийн хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламжийн санхүүжилтээр бараа, ажил, болон зөвлөхийн бус үйлчилгээ худалдан авах журам”-ыг хэлнэ.

Монгол Улсын Гадаад хэргийн яам
АЛБАН ЁСНЫ ОРЧУУЛГА МӨН

Гарын үсэг /Signature/

20/15 оны 06 сарын 2015 дөр
Улаанбаатар хот

11. “Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө” гэж Худалдан авах ажиллагааны журмын 1.18 болон Зөвлөхийн үйлчилгээний журмын 1.25 хэсэгт заасан , мөн эдгээр хэсгүүдийн дагуу тухай бүр нэмэлт, өөрчлөлт хийгдэх, 2015 оны 05 сарын 01 өдөр баталсан, Төсөлд зориулан Хүлээн авагчийн худалдан авах ажиллагаа хийх төлөвлөгөөг хэлнэ.
12. “Төсөл хэрэгжүүлэх гарын авлага” гэж Төсөл хэрэгжүүлэх нэгж дэх ажил үүргийн хуваарилалт, мөн үйл ажиллагааны систем болон журам, тухайлбал, Төсөл хэрэгжүүлэх нэгжийн зохион байгуулалтын бүтэц, оффисын үйл ажиллагаа болон журам, санхүү ба нягтлан бодох бүртгэлийн журам (үүнд: хөрөнгийн урсгал болон зарцуулалтын зохицуулалт), худалдан авах ажиллагааны журмыг багтаасан энэхүү хэлэлцээрийн Хуваарь 2-ийн 1 дэх хэсгийн Б.1 –т заасны дагуу Хүлээн авагч баталсан гарын авлагыг хэлнэ.
13. “Төсөл хэрэгжүүлэх нэгж” гэж энэхүү Гэрээний Хуваарь 2-ийн 1 дэх хэсгийн А.1-т заасны дагуу Төслийг хэрэгжүүлэх болон удирдах зорилгоор Хүлээн авагчийн байгуулан, цаашид үйл ажиллагаа явуулах нэгжийг хэлнэ.

Хэсэг II. Ерөнхий нөхцөлд оруулсан нэмэлт өөрчлөлт

Ерөнхий нөхцөлд дараахь байдлаар өөрчлөлт оруулсан. Үүнд:

1. 3.02 –р хэсгийг дараахь байдлаар өөрчлөв:

“Хэсэг 3.02. Үйлчилгээний болон хүүгийн хураамж”

(а) Үйлчилгээний хураамж. Хүлээн авагч тал нь зарцуулсан зээлийн дүнд Санхүүжилтийн Хэлэлцээрт заасан хувиар Ассоциацид үйлчилгээний хураамжийг төлнө. Үйлчилгээний хураамж нь зээлийн хөрөнгийг тодорхой хэмжээгээр зарцуулсан өдрөөс эхлэн тус бүр хуримтлагдах ба түүнтэй холбогдон үүсэх өрийн хэлбэрээр хагас жил тутамд Төлбөр төлөх хугацаанд нь төлж барагдуулна. Үйлчилгээний хураамжийг 30 хоног бүхий 12 сараар жилийн 360 хоногт үндэслэн тооцно.

(б) Хүүгийн хураамж. Хүлээн авагч тал нь зарцуулсан зээлийн үлдэгдэлд Санхүүжилтийн Хэлэлцээрт заасан хувиар Ассоциацид хүү төлнө. Хүү нь зээлийн хөрөнгийг тодорхой хэмжээгээр зарцуулсан өдриүүдээс эхлэн тус бүр хуримтлагдах ба түүнтэй холбогдон үүсэх өрийн хэлбэрээр хагас жил тутамд Төлбөр төлөх хугацаанд нь төлж барагдуулна. Хүүгийн хураамжийг 30 хоног бүхий 12 сараар жилийн 360 хоногт үндэслэн тооцно.

2. Нэмэлтийн 28 дахь хэсэг (“Санхүүжилтийн төлбөр”)-т “Үйлчилгээний хураамж” болон “Хөрөнгө нөөцлөн баталгаажуулсны хураамж” гэсэн үгсийн дунд “Хүүгийн хураамж” гэсэн үг оруулж өөрчилсөн.
3. Нэмэлтэд “Хүүгийн хураамж” гэсэн дараахь тодорхойлолттой 32 дахь хэсгийг нэмж оруулан, үлдсэн хэсгийг дахин дугаарлав. Үүнд:

“32. “Хүүгийн хураамж” гэж Санхүүжилтийн Хэлэлцээрийн 3.02(б) Хэсэгт заасан хүүгийн хураамжийг хэлнэ.”

4. Нэмэлтийн дахин дугаарлагдсан 37 дахь хэсэгт (анх 36 дахь хэсэгт байсан)

Монгол Улсын Гадаад хэргийн яам
АЛБАН ЁСНЫ ОРЧУУЛГА МӨН

Гарын үсэг /Signature/

2015 оны 06 сарын 21 өдөр
Улаанбаатар хот

Цахим эрүүл мэнд төсөл

(“Төлбөр хийх өдрүүд”)-ийг “Үйлчилгээний хураамж” болон “Хөрөнгө нөөцлөн баталгаажуулсны хураамж” гэсэн үгсийн дунд “Хүүгийн хураамж” гэсэн үг оруулж өөрчилсөн.

5. Нэмэлтийн дахин дугаарлагдсан 50 дахь хэсгийн (анх 49 дахь хэсэг байсан) (“Үйлчилгээний хураамж”)-ийг Хэсэг 3.02-ын тайлбарыг Хэсэг 3.02 (а) болгон орлуулж өөрчилсөн.